



ЭКОЛОГИЙН БҮТЭЭМЖ ХХК

**“ЧИНГИС ШАР АЙРАГ” ХХК-ИЙН
“ШАР АЙРГИЙН ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



**CHINGGIS
BEER**



2026



АГУУЛГА

ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	3
5.1.БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	3
5.1.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3
5.1.2.Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	7
5.1.3.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	7
5.1.4.Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	7
5.1.5.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	7
5.1.6.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	10
5.1.7.Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ	14
5.2.БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	17
5.3.БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	17
5.4.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ	19

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	4
Хүснэгт 2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний зардал.....	7
Хүснэгт 3. Арга хэмжээний төлөвлөгөө	8
Хүснэгт 4. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал	9
Хүснэгт 5. Ангилан ялгах хог хаягдлууд	11
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн зардал	13
Хүснэгт 7. Байгаль орчны менежментийн хүрээнд хэрэгжүүлэх ажил	14
Хүснэгт 8. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	15
Хүснэгт 9. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	15
Хүснэгт 11. БОМТ-г оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	17
Хүснэгт 12. Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр.....	18
Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2023 оны нийт зардал	19



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БОМТ	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БОННУ	БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ
ХХК	ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
БОАЖС	БАЙГЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД
БОХТ	БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ
ОХШХ	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР
МУЗГ	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХХАА	ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА
ОБГ	ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
БОАЖЯ	БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

ЧИНГИС ШАР АЙРАГ ХХК-ийн “Шар айргийн үйлдвэр” төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээн (БОННУ)-ий тайлан 2022 оны 4-р улиралд БОУАӨЯ-аар батлагдсан байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /шинэчилсэн найруулга/-н 9-р зүйлд зааснаар Байгаль орчны менежмент төлөвлөгөө (БОМТ) нь нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан баримт бичиг бөгөөд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-ний салшгүй хэсэг юм. “ЧИНГИС ШАР АЙРАГ” ХХК-ийн “Шар айргийн үйлдвэр” төслийн 2026 оны БОМТ-г Монгол улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хууль, БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаал хавсралтын дагуу холбогдох дүрэм журмын шаардлагад нийцүүлж боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

5.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “ЧИНГИС ШАР АЙРАГ” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

5.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны үндсэн бүрдэл хэсгүүд (агаар, ус, хөрс, газрын гадарга, амьтан гэх мэт)–ээр тооцож гаргасан төслийн үйл ажиллагааны хугацаанд биелүүлэх дараах арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулан, хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн төлөвлөгөөнд байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, сэргийлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан болно.



Хүснэгт 1. Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгж өртөг (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хууль эрх зүйн шаардлага
Агаарын чанар						
Түүхий эд, материалыг ачиж, буулгах, хаягдлын талбайд үүсэх тоосжилт	Хатуу хог хаягдлын цэгийг засаж тохижуулах, хогийн цэг нь ус борооноос хамгаалсан таглаатай, хог хаягдлыг ангилж хийх зориулалтын тасалгаатай, хогийн цэгийн суурийг бетондсон, хогийг ачиж, тээвэрлэх ажилд саад учруулахгүйгээр байршилтай, хогийн цэгийн орчимд тэмдэг тэмдэглэгээтэй байх шаардлагатай.	Үйлдвэрийн талбайд	Хог хаягдлыг бууруулах менежментэд тусгагдсан			Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Үйлдвэрээс голчлон задрах хог хаягдал үүсэх бөгөөд хаягдлын буруу хадгалалтаас үүсэх эвгүй үнэр орчинд тархах, амьдрах орчин доройтох, ажилчдын анхаарлыг сарниулах, тав тухтай ажиллах нөхцлийг алдуулах	Хатуу хог хаягдлыг ангилан хадгалах, зориулалтын саванд цуглуулах, хог хаягдлын цэгийг тохижуулах, ариутгал цэвэрлэгээг тогтмол хийх		Хог хаягдлын менежментэд тусгагдсан.			Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015
Тээвэрт ашиглаж буй машин техникээс үүсч болзошгүй хорт хий	Түгээлт, тээвэрлэлтэд ашиглагдаж буй автомашинуудын янданд агаарт хаягдах бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах шүүлтүүр суурилуулах	Тээврийн хэрэгслүүдэд	100.0	1 000.0	2026 онд	MNS 5002:2000
	Төсөл хэрэгжих хугацаанд мэргэжлийн байгууллагаар агаарын сорьц авахуулан шинжилгээ хийлгэж, зөвлөгөө авч байх	Үйлдвэрийн талбайд	ОХШХ-т дэлгэрэнгүй тусгасан.		2026 онд	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа,



“ЧИНГИС ШАР АЙРАГ” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТЫН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 6-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИЖ БУЙ “ШАР АЙРГИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйлдвэрийн технологи ажиллагаанаас үүсч болзошгүй хорт хий	Үйлдвэрийн агааржуулах системийг сайжруулах, агаар солилцоог тогтмол хийх	Үйлдвэрийн талбайд	Дотоод төлөвлөлтөөр			эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
Дотоод орчинд үүсэх дуу шуугиан, доргио чичиргээ	Ажилчдад сонсгол хамгаалах хэрэгсэл /чихэвч/ зүүлгэх, тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээг тогтмол хийх, БОХШХ-т тусгагдсан хяналт-шинжилгээг хийж хэвших		Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан			
Усны нөөц, чанар						
Үйлдвэрийн хаягдал усны бохирдол нэмэгдэх	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн ариутгал, цэвэрлэгээнээс гарч байгаа бохир усанд хяналт- шинжилгээ хийж байх	Үйлдвэрийн талбайд	ОХШХ-т тусгасан.			Усны тухай хууль Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль МУЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт
Тоног төхөөрөмжийн ариутгал цэвэрлэгээнд ашиглах химийн бодисыг хэтрүүлэн хэрэглэх, ажилчдын хайнга үйлдлээс ариутгах татуургын шугам сүлжээнд нийлүүлж буй бохир ус стандарт үзүүлэлтээс давах	Лабораторид хэрэглэгдэж байгаа болон үйлдвэрт ашиглагдаж, хадгалагдаж байгаа бодисуудын сав баглааны битүүмжлэл, бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж байх ёстой		Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан			
Цэвэр усны хэт их хэрэглээ	Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд технологийн зориулалтаар ашиглах усны нормыг хангаж ажиллах					
Хөрс, ургамал						
Хог хаягдал, химийн бодисын нөлөөгөөр орчны бохирдол үүсэх	Хатуу хог хаягдлыг тусгай цэгт цуглуулах, гэрээлэгч компани зайлуултал тодорхой хяналт хийх	Үйлдвэрийн талбайд	Хог хаягдлын менежментэд тусгагдсан			-
	Химийн бодисын агуулах нь тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан шингээгч материал, хуурай элс, тогтворжуулагч, үртэс, хоосон сав,	Үйлдвэрийн талбайд	500.0	500.0	2026 онд	



“ЧИНГИС ШАР АЙРАГ” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТЫН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 6-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИЖ БУЙ “ШАР АЙРГИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	хамгаалах хэрэгсэл, наалддаг шошго, бортого сав онгойлгогч, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тууз гэх мэтээр хангагдсан байх хэрэгтэй.					
НИЙТ (мян.төг)		1 500.0				



5.1.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

“Чингис шар айраг” ХХК-ний Шар айрагны үйлдвэр нь өөрийн эзэмшлийн нийт 658 м² талбайд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эзэмшлийн талбайн 90%-д барилга байгууламж баригдсан, үлдсэн хэсгийг бүхэлд нь хатуу хучилттай болгож зассан байна.

Төлөвлөгөөний хүрээнд үйлдвэрийн талбайд ногоон байгууламж байгуулах боломжгүй тул МУ-ын ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг тусгалаа.

- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэхдээ харьяа засаг захиргааны нэгжүүдтэй хамтран тэдгээрээр газар заалган мод тарих ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулах хэрэгтэй.
- Үйлдвэрийн гаднах нийтийн эзэмшлийн бага хэмжээний ногоон байгууламжийг нөхөн сэргээх, халцарч зулгарсан, сукцесст орсон хэсэгт нөхөн сэргээлт хийх. Үүнд олон наст өвслөг ургамлаар захын хэсгийг эмжээрлэн тарьж, түүний төв хэсэгт мандлын олон наст цэцгийг тарих нь байгууллагын үзэмжид тохиромжтой юм.

Хүснэгт 2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний зардал

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд холбогдох төрийн байгууллагуудтай хамтран, газар заалгаж мод тарих*	10 ш мод тарьж, ургуулах	-	1 000.0	2026 оны 10 сарын 2 дахь долоо хоногын Бямба гараг (Мод тарих үндэсний өдөр)	-
Үйлдвэрийн гаднах ногоон байгууламжийг арчлах, нөхөн сэргээх	Үйлдвэрийн гаднах зам дугуух ногоон байгууламж	Дотоод төлөвлөгөөгөөр		2026 онуудад	
Нийт/мян.төг/			1 000.0		

5.1.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Тухайн төсөл хэрэгжиж буй газар нь Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт хотын төв хэсэгт байрлана. Үйлдвэрийн буруу үйл ажиллагаанаас осол аваарь гарахаас бусад тохиолдолд оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх шаардлага үүсгэхгүй юм.

5.1.4. Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тухайн талбайд түүх соёлын дурсгалт зүйл байхгүй бөгөөд төслийн хэрэгжилтийн үед ямар нэг зүйл илэрсэн үед арга хэмжээ авна.

5.1.5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Тус үйлдвэрт хэрэглэх химийн бодисууд нь хяналт, туршилт хийгдсэн баталгаа бүхий гэрчилгээтэй, мөн хор аюулын лавлахтай MSDS, бодис тус бүрийг тохирсон



зориулалтын сав, хайрцагт савлаж битүүмжилсэн, хаяг шошго наасан байх хэдий ч тээвэрлэх, шилжүүлэн ачих, хадгалах, хэрэглэхэд осол эрсдэл гарах магадлалтай.

Үйлдвэрт хэрэглэх химийн бодисуудын сав хайрцагны овор хэмжээ, хаяглалт, холбогдох мэдээллүүд нь олон улсын стандарт, импортлогч болон хэрэглэгч үйлдвэрүүдийн технологийн дагуу хийгдсэн тохиолдолд хэвийн нөхцөлд тээвэрлэх болон шилжүүлэн ачих, хэрэглэхэд харшлах зүйлгүй гэж үздэг. Харин технологийн горимыг чанд сахихгүй байх, ажиллагсдын хайнга ажиллагаа зэргээс үүдэн осол гарвал химийн бодисын хор аюулаас үүдэн бий болох эрсдэл, үр дагавар нь ноцтой тул урьдчилан сэргийлэх иж бүрэн арга хэмжээ авч, эрсдлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах талаар бэлтгэл ажлыг зохих журмын дагуу хийсэн байх зайлшгүй шаардлагатай.

Химийн бодис тээвэрлэх, буулгах ажлыг ачаалал, хөл хөдөлгөөн харьцангуй багатай үед гүйцэтгэх нь тохиромжтой. Химийн бодисыг ачиж, буулгах үед уут сав задарвал химийн бодис асарч, алдагдаж болзошгүй. Хатуу шахмал бодисууд нь хуурай орчинд харьцангуй тогтвортой байдаг тул асарсан тохиолдолд хүрэээр хутган авч савлах, битүүмжлэх арга хэмжээ авдаг. Харин шингэн бодис асарвал ууршилт, тархалтаас сэргийлэх арга хэмжээг нэн яаралтай авах шаардлагатай.

Химийн бодисыг тээвэрлэх, хадгалах, хэрэглэхэд болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд бэлэн байдлыг хангах, осол эрсдлээс хамгаалах, хоргүйжүүлэх, саармагжуулах, гал унтраах арга хэмжээг шуурхай авах нөхцөлийг бүрэн бүрдүүлэх шаардлагатай.

Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

“Чингис шар айраг” ХХК-ний шар айрагны үйлдвэрийн үйл ажиллагааны явцад химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах явцад хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, гарсан хор уршгийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 3. Арга хэмжээний төлөвлөгөө

№	Байршил	Эрсдэл	Арга хэмжээ
1	Үйлдвэрийн химийн бодисын агуулах	Бага	<ul style="list-style-type: none">Химийн хорт болон аюултай бодисын агааржуулалтыг сайжруулахАсгаралт ба харьцах явцад үүсэх аюулын тухай ажилтнуудад сургалт хийхНийт ажилтнуудад асгаралтын үед авах арга хэмжээний тухай сургалт зохион байгуулахАсгаралтын үед ашиглах шаардлагатай нөөцөөр хангахТос, тосолгооны материал хадгалах зориулалтын талбай бэлдэхХаягдал тосыг хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааг тогтмол хянах



**“ЧИНГИС ШАР АЙРАГ” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТЫН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 6-Р ХОРООНЫ НУТАГ
ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИЖ БУЙ “ШАР АЙРГИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 4. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Химийн бодисын сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдах, орчинд тархах	Шаардлагатай үед алдагдсан химийн бодисыг цэвэрлэх, саармагжуулах арга хэмжээ авах, багаж хэрэгсэлтэй болох	Ус, элс шороо, хүрз, цэвэрлэгээний бодис гэх мэт	500.0	500.0	2026 онд
Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбартай болох	Химийн бодисыг ачиж буулгах, тээвэрлэх, хадгалах зэрэг үйл ажиллагаа-нуудын үед хэрэгжүүлэх ХХАА-ны гарын авлагатай болох	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		
	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл, холбооны хэрэгсэлтэй болох	Ус, элс шороо, хүрз, цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт	-	-	-
	Болзошгүй аюул ослын үед ашиглах мөнгөн хуримтлал бүрдүүлэх	-			
Химийн бодис алдагдах, асгарах зэргээр ажилчдын эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй	Ажилчдад хүчил шүлтэнд тэсвэртэй зориулалтын хөдөлмөр хамгааллын хувцас өмсгөх, зориулалтын угаалгын өрөөнд угааж, цэвэрлэх	Бээлий, нүдний шил, нүүрний хаалт, чихэвч	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		
Нийт зардал (мян.төг)			500.0		



5.1.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын менежмент гэдэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлын эх үүсвэрийг бууруулах, ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах бүхий л процессыг хянаж сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь хог хаягдлын менежментийн хүрээнд цаашдын авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хог хаягдлыг газар дээр нь ангилан ялгах нөхцөл бололцоог хангаж ажиллах үүрэгтэй.

Эзэмшил газрынхаа ойр орчны цэвэрлэгээг тогтмол хийх, үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлыг тогтоосон цэгт хуримтлуулж тогтмол хугацаанд зайлуулах, ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хаягдлыг ашиглах, аливаа зүйлээр бохирдсон хог хаягдлыг саармагжуулах, галын аюулаас хамгаалах, хадгалалт хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.


Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хадгалахдаа хогийн сав болон хогийн цэгийг өнгөөр ялгаж зургаар тэмдэгжүүлснээр хуурай хог хаягдлыг стандартын дагуу ачиж, тээвэрлэх хадгалах нөхцөл бүрдэхээс гадна байгаль орчинд сөрөг нөлөөгүй бохирдолгүй амьдрах нөхцөл бололцоо бий болох юм.

Хатуу хог хаягдлаа ялган ангилсны ач холбогдол:

- Цаас, шил, мод, яс, хуванцар, металл, органик гаралтай хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах боломж бий болно.
- Орчныг бохирдуулах, устгал хийх хогны хэмжээ эрс багасна.
- Хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ачиж тээвэрлэх боломж бүрдэнэ.
- Хүн амын аюулгүй, цэвэр, эрүүл орчинд ажиллах, амрах нөхцөл бүрдэнэ.
- Амьтан, ургамал, хөрс, усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Төслийн үйл ажиллагаанаас хатуу, шингэн хог хаягдал, болон барилгажилтын үе шатанд барилгын хог хаягдал гарах ба үүнээс хатуу хог хаягдлыг ахуйн болон аюултай хог хаягдал хэмээн ялгаж тус бүрд нь тохирсон арга хэмжээг авч ажиллана.

Энгийн хог хаягдлын менежмент: Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн талбайд Хог хаягдлын цэгийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаалын хавсралт “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ын дараах заалтын дагуу барьж байгуулан ашиглах шаардлагатай.



Зураг 5.1. Хог хаягдлын цэгийн шийдэл

Төслийн талбайд байгуулах Хог хаягдлын цэгийг Зураг 5.1-д заасны дагуу битүүмжлэлтэй, цоожтой лист төмрөөр хийгдсэн байхаар хийх боломжтой ба хог хаягдлыг энгийн, дахивар, аюултай хог хаягдал зэрэг 3 ангилан ялгах нь зүйтэй.

Хүснэгт 5. Ангилан ялгах хог хаягдлууд

Энгийн хог хаягдал	Дахивар хог хаягдал	Аюултай хог хаягдал
<ul style="list-style-type: none"> ✓ Хоолны үлдэгдэл; ✓ Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл; ✓ Яс; ✓ Хэрэглэсэн хүнсний тос ✓ Аюултай болон дахин боловсруулах хог хаягдлаас бусад хог хаягдал 	<ul style="list-style-type: none"> ✓ Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савлагаа/ ✓ Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, 0,025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав, гм/ ✓ Хөнгөн цагаан, төмөр, метал, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйл; ✓ Шил /хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл/; ✓ Лааз; ✓ Мод, модон эдлэлийн хаягдал; ✓ Хувцас, даавуун эдлэл; ✓ Савхи, резин; ✓ Өвс, мод. 	<p>Аюултай хог хаягдал гэж амьтан, ургамлыг өвчлүүлэх, гэмтээх, тэдгээрийн үр удамд хор хөнөөл учруулах болон байгаль орчны хэвийн төлөв байдалд сөрөг нөлөөтэй хортой, идэмхий, исэлдүүлэгч, шатамхай, дэлбэрэх хог хаягдлыг хэлнэ.</p> <p>Иймд төслийн талбайн машин засварын цехийн үйл ажиллагаанаас гарч буй нефть болон газрын тосны бүтээгдэхүүн агуулж буй сав, савны цэвэрлэгээнд ашигласан цэвэрлэгээний материал, тос тосон бүтээгдэхүүн агуулж буй савны хаягдлыг энэ цэгт төвлөрүүлж Хог хаягдал тээвэрлэх машинд ачуулж тусгай цэгт хүргүүлнэ.</p>

Хог хаягдлыг цуглуулахад тавигдах ерөнхий шаардлага



- 2.3.1.** Энгийн хог хаягдлыг цуглуулах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.8-д заасныг ойлгох ба хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас гадна энэхүү тавигдах ерөнхий шаардлагын 2.3.2-2.3.5-д заасан ерөнхий шаардлага хамаарна.
- 2.3.2.** Хог хаягдлын тухай хуулийн 14.2-т заасан гэрээнд хог хаягдал цуглуулах төрөл, хэлбэр, хогийн цэгийн байршил, ажиллах цагийн хуваарь, орчны тохижилт, ариун цэврийн шаардлагын талаар тодорхой тусгасан байна.
- 2.3.3.** Хог хаягдлыг цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмж гэж энгийн хог хаягдлыг тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах зорилгоор хог хаягдлыг цуглуулж байгаа хог хаягдал үүсгэгчийн ойролцоо байршуулсан савыг хэлэх ба дараах ерөнхий шаардлага хангасан байна.
- Хог хаягдал цуглуулах сав, төхөөрөмжийг сум, хорооны Засаг даргын зөвшөөрсөн хэлбэр, хэмжээ, зориулалт болон заасан газарт байгуулна.
 - Орон сууцны хороолол, нийтийн эзэмшлийн талбай, явган хүн, авто машины хөдөлгөөнд саад учруулахааргүй газар байна.
 - Хог хаягдал хийсэх, агаар болон хөрсөнд тархах, шингэх, уусах, үнэр тархахгүй нөхцөлийг бүрдүүлсэн байна.
 - Хог хаягдлын төрөл, ангиллын мэдээллийг ил харагдахуйц байршуулсан байна.
 - Байгаль орчинд сөргөөр үл нөлөөлөх нөхцөлөөр буюу чанарын шаардлага хангасан байна.
 - Тээвэрлэх зориулалт бүхий уяа, дэгээтэй, хог хаягдал ачих тээврийн хэрэгсэлд зориулагдсан байна.
 - Хог хаягдал цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмжийн хог хаягдал хадгалах, цуглуулах багтаамж 3 хоногоос ихгүй байна.
- 2.3.4.** Хог хаягдал цуглуулах иргэн, аж ахуй нэгж, байгууллагын ажилтан нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зохих мэдлэгтэй байх;
 - Хөдөлмөр хамгааллын нэг бүрийн хэрэгсэл хэрэглэх;
 - Хог хаягдал цуглуулах үйл ажиллагааны бүрэн мэдлэгтэй, хог хаягдал үүсгэгчийн онцлогийг тодорхойлох чадвартай байх.
- 2.3.5.** Хог хаягдлын цуглуулахдаа ангилан ялгасан хог хаягдал тус бүрээр цуглуулна.



“ЧИНГИС ШАР АЙРАГ” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТЫН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 6-Р ХОРООНЫ НУТАГ
ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИЖ БУЙ “ШАР АЙРГИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн зардал

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нэгжийн өртөг, (мян.төг)	Нийт зардал, (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг өөрийн үйл ажиллагаанд тохируулан боловсруулж батлуулах, хэрэгжүүлж ажиллах.	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны туршид	-	-	2026 он	Хог хаягдлын тухай хууль, эрүүл ахуйн тухай хуулийн 4.4.3 зүйл, 13.1.6 зүйл, Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам
2	Хогийг ангилах ялгах, цэгийг сайжруулах, байнгын арчилгаа тордолт хийх, талбайн зонхилох салхины доод талд багтаамж сайтай хогийн сав байршуулах, ангилан ялгах тэмдэг тэмдэглэгээтэй болгох, ажилчид үйлчлүүлэгчид хог хаягдлаа ил задгай хаяхгүй байхыг анхааруулсан самбар, тэмдэг тэмдэглэгээ байршуулах.	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны туршид	400.0	400.0	2026 он	
3	Талбай болон ажлын байрыг тогтмол цэвэрлэж байх. Ажилчдыг цэвэрлэгээний бодис хэрэглэлээр байнга хангаж байх хэрэгтэй.	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны туршид	200.0	200.0	2026 он	
4	Аюултай хог хаягдал /Химийн бодисын сав баглаа, боодол/	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны туршид	Дотоод төлөвлөгөөгөөр		2026 он	
5	Аюултай хог хаягдал /Цар тахлын үед гарах хог хаягдал/	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны туршид	Дотоод төлөвлөгөөгөөр		2026 он	
2026 оны хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал						600.0	



5.1.7. Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ

Төсөл хэрэгжүүлэгч “Чингис шар айраг” ХХК нь удирдлага зохион байгуулалт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах дараах ажлуудыг гүйцэтгэх нь зүйтэй юм. Мөн эдгээр ажлуудыг хариуцан гүйцэтгэх байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн ажиллуулах нь зүйтэй юм.

Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр байгаль орчныг менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах, жилийн эцэст БОМТ-ний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, байгаль орчны хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор компанийхаа дотоод дүрэм, журамд өөрчлөлт оруулах, ОБГ, МХГ зэрэг газруудаар үйлдвэр дээрээ хяналт тавиулж, ажилчдынхаа дунд галын аюулгүй ажиллагаа, химийн бодистой аюулгүй ажиллах, хөдөлмөр хамгааллын сургалтуудыг зохион байгуулах, осол эрсдлээс хамгаалах ажлыг зохион байгуулах

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах ажлууд: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр ажилчдад ажлын байрны онцлог тус бүрт нийцсэн ажлын хувцас хэрэгслийг олгох, химийн бодистой харьцаж ажилладаг ажилтанд хор саармагжуулах бүтээгдэхүүнийг ажлын байранд тогтмол олгох, жил бүр ажиллагсдаа эмнэлгийн байгууллагатай хамтран эрүүл мэндийн 5-8 төрлийн үзлэг шинжилгээнд хамруулан, нарийн мэргэжлийн эмч нараар ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөө өгүүлэх, шаардлагатай тохиолдолд ажилтнуудыг амбулаториор эмчилгээнд хамруулдаг байна. Мөн машин тоног төхөөрөмж дээр ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг байрлуулж, цехийн мастерууд ажилд гарахын өмнө ажиллагсдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч ажиллуулж байх, ажилчдын ажлын хувцас, хэрэглэлийг тогтмол хэрэглүүлж занших, ажлын байранд яаралтай үед хэрэглэх түргэн тусламжийн багаж хэрэгсэл, эм тариа бэлтгэх

Хүснэгт 7. Байгаль орчны менежментийн хүрээнд хэрэгжүүлэх ажил

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг	Хариуцагч
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх, шинэчлэн засварлах	Жил бүр	Дотоод зохион байгуулалтаар	
2	Байгаль орчныг хамгаалах, осол аваарь, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	2026 онд	400.0	Төсөл хэрэгжүүлэгч
3	Байгаль хамгаалах талаар хийх ажлын төлөвлөгөө(тухайн жилийн БОМТ)-г БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газарт, хийсэн ажлын тайланг (биелэлтийн тайлан) нийслэлийн байгаль орчны газарт хүргэн өгч, хянуулах, батлуулан	Жил бүрийн 12 сард	Дотоод зохион байгуулалтаар	



	хэрэгжүүлэх		
4	Байгаль хамгаалахад хороо, дүүргийн холбогдох ажилтнуудын оролцоог идэвхижүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-нд тусгах	2026-2027 онуудад	-
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал			400.0

Хүснэгт 8. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг	Хариуцагч
1	Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх осол эрсдлийг илрүүлэх, хөдөлмөр хамгаалал болон болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх, осол аваарын үед авах арга хэмжээний төлөвлөгөө гарган цаг үеийн байдалтай уялдуулан тодотгол хийж	2026 онд	Дотоод төлөвлөлтөөр	Төсөл хэрэгжүүлэгч
2	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө	2026 онд	Дотоод төлөвлөлтөөр	Төсөл хэрэгжүүлэгч
3	Бүх ажиллагсдыг жилд 1 удаа нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулж байх	2026 онд	Дотоод төлөвлөлтөөр	Төсөл хэрэгжүүлэгч
Нийгэм-эдийн засгийн нөлөөллийг бууруулах ажлын зардлын нийт дүн			-	

Хүснэгт 9. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Хийгдэх ажил	Хугацаа	Зардал мян.төг	Хариуцах ажилтан
1	Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах сургалт зохион байгуулах, галын аюулгүй ажиллагааны талаар дүүргийн ГТТХЭлтэстэй хамтран галын аюулаас урьдчилан сэргийлэх үзүүлэх сургууль хийх	4-р улирал	200.0	Төсөл хэрэгжүүлэгч
2	ХХААЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	Улирал бүр	Дотоод төлөвлөлтөөр	Төсөл хэрэгжүүлэгч
3	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах хэрэгсэл, амны хаалт, малгай зэргээр хангах	жилдээ	Дотоод төлөвлөлтөөр	Нярав
4	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	Сар бүр	200.0	Төсөл хэрэгжүүлэгч
5	Ажилчдын эрүүл мэндэд хор хөнөөл учрахаас сэргийлэн тэжээллэг, хордлого тайлах хоол хүнс, тухайлбал сүү, аарц, гүүний саам зэргээр хангах зардал	Өдөр бүр	Дотоод төлөвлөлтөөр	Төсөл хэрэгжүүлэгч
Дүн			400.0	

Байгаль орчны төлөвлөгөөт аудитын зардал: Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А-126 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 2.1-д “Төлөвлөгөөт аудитыг хоёр жил тутамд, төлөвлөгөөт бус аудитыг Засаг дарга, эсхүл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аудит хийлгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хийнэ” хэмээн заасны дагуу аж ахуйн нэгж өөрийн зардлаар аудит хийлгэнэ.



Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Урьдчилан тооцсон төсөв /мян.төг/	Хэрэгжүүлэх хуваарь	Баримтлах хууль, журам, стандарт, аргачлал
1	Төсөл хэрэгжүүлэгч нь Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 10 ¹ дүгээр зүйлд заасны дагуу 2 жилд тутамд байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлж ажиллах шаардлагатай. Байгаль орчны аудит хийх зардлыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан болно	Төрийн захиргааны төв байгууллага /БОУАӨЯ/	-	2 жилд 1 удаа	“Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 10 ¹ дугаар зүйлд,
2	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх	ГЗБГЗЕГ	Үйл ажиллагааны төсөвт суулгасан	5 жилд 1 удаа	Газрын тухай хуулийн 58-р зүйл
3	Дүүргийн санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	ХУД ЗДТГ болон 3-р хорооны ИНХТ	Үйл ажиллагааны төсөвт суулгасан	Жилд 1 удаа	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
4	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Үйл ажиллагааны үед	Үйл ажиллагааны төсөвт суулгасан	Жилд 1 удаа	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
5	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ	Төрийн захиргааны төв байгууллага /БОУАӨЯ/	Өмнөх нь БОННУ тайланд тусгагдсан	Жил бүр 12-р сар	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах	Нийслэлийн байгаль орчны газар		Жил бүрийн 11 дүгээр сарын 01	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ					800.000



5.2. БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Хүснэгт 11. БОМТ-г оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зардал (мян.төг)
Дүүргийн ИТХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Нутгийн иргэдийн саналыг хавсаргах	300.0 (жилд)
БОУАӨЯ-ны ХБОБНУГ-т	-	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	-	-
Нийт					300.0

5.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Чингис шар айраг” ХХК -ний шар айрагны үйлдвэрийн үйл ажиллагааны явцад БОННУ-ний тайлан, БОХТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол дээжлэлт, хяналт хийж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт тусгав.

БОХШХ нь байгаль орчин, нийгэм-эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно. Цаашдаа БОХТ-г улам боловсронгуй болгох байгаль орчин, нийгэм-эдийн засгийн болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг илүү нарийвчлан тогтоох боломжтой болно.

БОМТ-г жил бүр шинэчлэн боловсруулж тухайн оныхоо эхэнд БОУАӨЯ-аар батлуулж, оны эцэст тэдгээрийн биелэлтийг мөн БОУАӨЯ-д тайлагнана. Хяналт-шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргаар, стандартын дагуу шинжлүүлнэ.

Хяналт шинжилгээний үр дүнг хянах үйл ажиллагааг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудаар, хороо дүүргийн хөндлөнгийн хяналтын доор гүйцэтгэх зэргээр оролцогч талуудын хяналтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй юм.



**“ЧИНГИС ШАР АЙРАГ” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТЫН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 6-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИЖ
БҮЙ “ШАР АЙРГИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 12. Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1. Агаарын чанар					
1.1	Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ	Төслийн талбайн 2 цэгт (Дотоод, гадаад орчин)	Жилд 2 удаа /2-р сар, 7-р саруудад/	1 жил*500.0 мян.төг/жил =500.0	<ul style="list-style-type: none"> ❖ MNS 4585: 2016 Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага ❖ MNS0017-2-3-16:1988. Агаар мандал-Хот суурины агаарын бохирдлын шинжилгээ ❖ MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага ❖ MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага ❖ MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ
1.2	Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин)				
1.3	Бохирдлын цэгэн эх үүсвэр (O ₂ , SO ₂ , NO ₂ , CO)				
2. Усны хяналт шинжилгээ					
2.1	- Усны ерөнхий шинжилгээ: Анион, катион - Усны хүнд металл: хүнцэл As, кадми Cd, кобальт Co, хром Cr, зэс Cu, молибден Mo, никель Ni, хар тугалга Pb	Ундны усны дээжлэлт	Жилд 2 удаа	1 жил*2*150.0 мян.төг/жил=300.0	<ul style="list-style-type: none"> ❖ MNS 0900: 2018, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ ❖ MNS 6148:2010 Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт ❖ MNS 4943:2008 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага <ul style="list-style-type: none"> ❖ MNS ISO 10523-2:2003 pH тодорхойлох ❖ MNS ISO 4889-99 Цахилгаан дамжуулах чанар тодорхойлох <ul style="list-style-type: none"> ❖ MNS ISO 6059:2005 Хатуулаг тодорхойлох ❖ MNS ISO 2572-99 Кальци тодорхойлох ❖ MNS ISO 9297:2005 Хлорид, тодорхойлох MNS 4425:97 Гидрокарбонат тодорхойлох тавих хяналт
2.2	Усны бактериологи: Үнэр, Умбуур бодис, БХХ5, ХХХ, ПИЧ,	Үйлдвэрийн бохир ус	Жилд 2 удаа	1 жил*2*140.0 мян.төг/жил= 280.0	
3. Хөрс					
3.1	Хөрсний үржил шимийн үзүүлэлт (рН, ялзмаг, карбонат, Ca ²⁺ , Mg ²⁺ , K ₂ O, P ₂ O ₅) механик бүрэлдэхүүн, хүнд металлууд (Cr, Pb, Cd, Ni Zn)	Төслийн талбайн 1 цэгт (Үйлдвэрийн гадна зам дагуу нийтийн эзэмшлийн талбай)	Жилд 2 удаа /2-сар, 7 саруудад/	Механик бүрэлдэхүүн 49.0 Хүнд металл: 30.0 (Ханлаб ХХК-ийн үнэ болно.) Нянгийн үзүүлэлт 30.0 (ШУА-ийн Ерөнхий	<ul style="list-style-type: none"> ❖ MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ ❖ MNS 3310:91, Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох ❖ MNS 3298:1990 хөрсний шинжилгээний дээж авах ерөнхий шаардлага ❖ MNS 3307:91, хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга <ul style="list-style-type: none"> ❖ MNS ISO 10390, Хөрсний чанар. рН тодорхойлох ❖ MNS 4006:1988, Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох <ul style="list-style-type: none"> ❖ MNS 2143:2000, Хөрсний физик шинж чанарыг



“ЧИНГИС ШАР АЙРАГ” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТЫН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 6-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИЖ
БУЙ “ШАР АЙРГИЙН ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

			болон Сорилын Биологийн Хүрээлэнгийн үнэ болно.) Нийт: 218.0	тодорхойлох арга
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2025 ОНЫ НИЙТ ЗАРДЛЫН ДҮН				1 298.0 мян.төг

Төслийн байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардал, түүний хуваарилалтыг Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж өгсөн ба жил бүр шинэчлэн тооцож байх шаардлагатай болно.

5.4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2026 оны нийт зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Нийт зардал (мян.төг)
1	Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1 500.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1 000.0
3	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	500.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	600.0
8	Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал	800.0
9	БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	300.0
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийт зардал	1 298.0
2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал /урьдчилсан байдлаар/		5 998.0